



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/140

Улаанбаатар хот

**Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн 2
барилгыг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 42 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/516 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2020 оны 02-07-383/157 тоот дүгнэлтийн дагуу тус Цагдаагийн хэлтсийн балансад бүртгэлтэй нийт 144 724 336.98 /нэг зуун дөчин дөрвөн сая долоон зуун хорин дөрвөн мянга гурван зуун гучин зургаан төгрөг ерэн найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан 2 барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс /П.Энхбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,497,000 /нэг сая дөрвөн зуун ерэн долоон мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс /П.Энхбаяр/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115070000391

Нийслэлийн Өмчийн Ашиглалт, Удирдлагын газрын
2020 оны ...04... дүгээр сарын ...20... өдрийн
0/140... дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллага: Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашигласан жил	Нэгжийн үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ /төгрөг/	Данснаас хасах үндэслэл
1	Эрүүлжүүлэх байрны барилга	Налайх дүүргийн 2 дугаар хороо	17	133 633 727.33	6 681 686.4	126 952 040,93	НИТХ-н 2019 оны 12 дугаар сарын 16-ны 9/36 дугаар тогтоолоор Цагдаагийн хэлтсийн шинэ барилга баригдахаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад орсон
2	Автомашин ы гарааш	Налайх дүүргийн 2 дугаар хороо	27	11 090 609.65	1 232 289.96	9 858 319.68	
НИЙТ ДҮН				144 724 336.98	7 913 976.36	136 810 360.62	